

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2018 он)

1. ATR72 JU-8802 IFSD incident

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/01 PWC, Honeywell компаниудад. /Safety recommendation 201812/01.To Pratt & Whitney Canada and Honeywell/.

PW127 серийн хөдөлгүүрт суурилагддаг НМУ эд ангийн задаргааны үед зөвхөн үзлэгээр хязгаарлагдалгүй холхивчийг солих шаардлагыг эд ангийн техник үйлчилгээний зааварт (СММ 73-20-61) тусгах, холхивч солих үечлэлийг хөдөлгүүр үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний зааварт тусгагдсан шаардлагатай уялдуулан тогтоох

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/02 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/02. МСАА/. Орон нутгийн нисэх буудлуудад шатахуун хадгалах, агаарын хөлөгт сумлах үйлчилгээг ИНД-144 дүрмийн дагуу гэрчилгээжүүлэн үйл ажиллагаа, чанарын хяналтын тогтолцоог олон улсын иргэний нисэхийн байгууллагын Doc 9977-д тусгагдсан зөвлөмж, стандарт болон үндэсний MNS 6591:2016 стандартад нийцүүлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/03 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/03. МСАА/.

Шатах тослох материалын шинжилгээ хийж ИНЕГ-ын харьяа лабораториудыг ИНД-144 дүрэм, холбогдох стандартуудад заагдсан шаардлагатай шинжилгээг бүрэн хийх, хүний хүчин зүйлийн нөлөөг багасгасан орчин үеийн шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг авах

2. F-50, JU-8883 incident

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/04 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/04. То МСАА/. PW100 серийн хөдөлгүүрийн НМУ эд ангийн их засварын үечлэлийг тогтоон агаарын тээвэрлэгч нарын техник үйлчилгээний хөтөлбөрт тусгуулан мөрдүүлэх арга хэмжээ авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/05 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/05. То МСАА/. Дадлагажуурын давтан сургалт, шалгалтын үед багш, шалгагч нарын нисгэгчийн ур чадвар, мэдлэгийн талаар өгсөн үнэлэлт, зөвлөмжийг тогтмол бүртгэн дүн шинжилгээ хийж зохих сургалт, шалгалтын хөтөлбөрт тусгах болон бусад хобогдох арга хэмжээг авч байх тогтолцоог бүрдүүлэх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/06 Хүннү Эйр ХХК-т. /Safety recommendation 201812/06. Хүннү ХХК/.

Агаарын хөлгийн нислэгийн заавар /AFM/, онцгой тохиолдлын үеийн заавар /ABNORMAL PROCEDURES/-г нисгэх бүрэлдэхүүнд давтан сургалтыг зохион байгуулж үйл ажиллагаандаа хэвшүүлэх;

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/07 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/07. То МСАА/. Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх /ATPL/-ыг 2016, 2017, 2018 онд авсан эзэмшигчдийн анх үнэмлэх авах үеийн нислэгийн цагийн тооцоо ба тавигдах шаардлагыг ИНД-61-ийн 61.31 ба 61.253-ийн дагуу хангагдаж байгаа эсэхийг дахин шалгаж дүгнэлт гаргах

3. Судалгаанаас үндэслэн

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/08 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/08. МСАА/.

Ханбумбат нисэх буудлын орчинд шувуу агаарын хөлөгтэй удаа дараалан мөргөлдсөн нөхцөл байдлыг мэргэжлийн үүднээс судлах, ориентолог-ийн судалгаа шинжилгээг хийлгэж холбогдох арга хэмжээ авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201812/09 ИНЕГ-т. /Safety recommendation 201812/09. МСАА/. Ханбумбат нисэх буудлын шувуутай мөргөлдөх аюулаас хамгаалах /airport bird control programmes/хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх

4. Хамтран ажилласан

Ан-2, ТВС-2МС, осол, Улаанбаатар

МАК дараах аюулгүй ажиллагааны зөвлөмжүүдийг RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн ослыг шинжлэн шалгасан тайлангийн 5 дугаар бүлэг, 39 дүгээр хуудсанд тусгажээ. Үүнд:

ОХУ-ын нисэхийн эрх баригч нарт

- Ан-2, ТВС-2МС маягийн агаарын хөлгийг ашиглагч нисэхийн ажилтнуудад ТВС-2МС маягийн RA-2099G бүртгэлийн дугаартай агаарын хөлгийн ослын шинжлэн шалгах ажиллагааны үр дүнгийн талаар мэдээлэх,
- Илэрсэн аюулын хүчин зүйлсийг харгалзан оршиж байгаа эрсдэлүүдийг үнэлж, ТВС-2МС маягийн агаарын хөлгийг цаашид аюулгүй ашиглахтай холбоотой зохих шийдвэрийг гаргах,
- Нислэгийн туршилтийн үр дүн болон ашиглалтын төвлөрөлтийн хязгаарыг тогтоосон үндэслэлийг дахин шалгах

Агаарын тээврийн компаний удирдлага болон хувийн эзэмшигч нарт

- Үндсэн баазаас өөр байрлалд нислэг үйлдэж буй нисэх багийн ажлыг үечлэлтэйгээр шалган заавал мөрдөх баримт бичигт тогтоогдсон шаардлагыг биелүүлж байгаа эсэхийг хянах,
- Ан-2, ТВС-2МС маягийн агаарын хөлгийн нисэх бүрэлдэхүүнд РЛЭ зааврын дараах бүлгүүдээр нэмэлт сургалт хийх:
 - Ашиглалтын ерөнхий хязгаарлалтын талаарх «Общие эксплуатационные ограничения» бүлэг («Максимальное количество людей на борту», «Максимальная взлетная и

- посадочная масса самолета», «Диапазон центровок самолета», «Эксплуатационные ограничения самолета» дэд бүлгүүд);
- Нислэгийн бэлтгэлийн талаарх «Подготовка к полету» бүлэг («Общие указания по расчету полетов» дэд бүлэг);
 - Нислэг үйлдэх талаарх «Выполнение полета» бүлэг («Особенности поведения самолета на больших углах атаки» бүлэг).
- Нислэгийн өмнөх агаарын хөлгийн төвлөрөлтийн тооцоог төвлөрөлтийн график болон хүндийн төвийн харьцангуй моментын аргуудыг ашиглан хийх тухай сургалт, дадлагыг нисэх бүрэлдэхүүнд хийх,
- Тухайн агаарын хөлгийн хөөрөлтийн хамгийн их жин, төвлөрөлтийн тооцоог хийхэд шаардлагатай болон техникийн хяналтын бусад баримт бичгүүд агаарын хөлөгт бүрт бүрэн байгаа эсэх, тэдгээрийг цаг тухайд нь бөглөж байгаа эсэхийг шалгах арга хэмжээг авах зэрэг болно.